



## ГАРЧИГ

### МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

339. Элчин сайдыг тохоон томилох тухай Дугаар 154 1429

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

340. Дүрэм шинэчлэн батлах тухай Дугаар 245 1429

341. Журам шинэчлэн батлах, журамд өөрчлөлт оруулах тухай Дугаар 271 1433

### МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2013 оны 09 дүгээр  
сарын 18-ны өдөр

Дугаар 154

Улаанбаатар  
хот

#### Элчин сайдыг тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Булгаагийн Алтангэрэлийг эгүүлэн татаж, Монгол Улсаас Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Банзрагчийн Одонжилийг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Ц.ЭЛБЭГДОРЖ**

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2013 оны 7 дугаар  
сарын 6-ны өдөр

Дугаар 245

Улаанбаатар  
хот

#### Дүрэм шинэчлэн батлах тухай

Архидан согтуурахтай тэмцэх хуулийн 13<sup>2</sup> дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:



1. Архидан согтуурахтай тэмцэх сангийн дүрмийг нэгдүгээр хавсралтаар, Архидан согтуурахтай тэмцэх сангийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг “Засгийн газрын комисс, хороо, үндэсний зөвлөл, ажлын хэсгийн бүрэлдэхүүний тухай” Засгийн газрын 2012 оны 98 дугаар тогтоолын 20 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Засгийн газрын 2004 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн 85 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Н.АЛТАНХУЯГ**

**ХУУЛЬ ЗҮЙН САЙД**

**Х.ТЭМҮҮЖИН**

Засгийн газрын 2013 оны 245 дугаар  
тогтоолын хавсралт

## АРХИДАН СОГТУУРАХТАЙ ТЭМЦЭХ САНГИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Архидан согтуурахтай тэмцэх сан (цаашид “Сан” гэх)-гийн зорилго нь архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх, хяналт тавих, архидан согтуурсны улмаас хүн амын эрүүл мэнд, нийгэмд учирч байгаа хор уршгийг арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээг санхүүжүүлэхэд оршино.

1.2. Сангийн үйл ажиллагааг сангийн зөвлөл (цаашид “Зөвлөл” гэх) удирдах бөгөөд зөвлөлийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тэргүүлнэ.

1.3. Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байх бөгөөд жилд нэгээс доошгүй удаа хуралдана. Зөвлөлийн гишүүдийн олонхи оролцсоноор хуралдааныг хүчинтэйд тооцно.

1.4. Зөвлөл хэлэлцсэн асуудлаа олонхийн саналаар шийдвэрлэнэ. Зөвлөлийн хуралдааны явцын тухай тэмдэглэл хөтөлнө.

Хоёр. Сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалт

2.1. Сангийн хөрөнгө Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 13<sup>2</sup>.2-т заасан эх үүсвэрээс бүрдэнэ.



2.2. Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 13<sup>2</sup>.4-т заасныг үндэслэн дараах үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийг Засгийн газар санхүүжүүлж болно:

2.2.1. архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх, архины хор уршгийг бууруулах талаар улсын хэмжээнд авч хэрэгжүүлэх нэгдсэн арга хэмжээ;

2.2.2. архидан согтуурснаас олон нийтэд үзүүлж байгаа сөрөг нөлөөлөл, үр дагаврыг тогтоох судалгаа, шинжилгээний ажил;

2.2.3. архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, сурталчилгаа явуулах, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагын оролцоог дэмжих;

2.2.4. архидан согтуурснаас үүдэлтэй гэмт хэрэг, зөрчил үйлдсэн этгээдийг судалж, архины хамааралтай сөрөг зан үйлд нь нөлөөлөх, улмаар сургалт, хөдөлмөрийн арга барил, дадал чадварыг эзэмшүүлэх, суллагдан гарсны дараа сургалт, хүмүүжлийн тусгай хөтөлбөрт түр хугацаагаар хамрагдах боломжийг бүрдүүлэх.

2.3. Сангийн хөрөнгийг Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 13<sup>2</sup>.6-д заасан зориулалтаар зарцуулна.

#### Гурав. Зөвлөлийн бүрэн эрх

3.1. Сангийн зөвлөл дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

3.1.1. сангийн үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх;

3.1.2. сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрийг шалгаруулах;

3.1.3. сангийн хөрөнгөөр санхүүжүүлж байгаа арга хэмжээ, төсөл, хөтөлбөрийн явцад хяналт тавих, тайланг хэлэлцэх.

#### Дөрөв. Бусад зүйл

4.1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Зөвлөлийн өдөр тутмын үйл ажиллагааг Хууль зүйн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар хариуцах бөгөөд дараах байдлаар зохицуулна:

4.1.1. Зөвлөлийн шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах;



4.1.2. Сангийн хөрөнгийг төвлөрүүлэх, зарцуулахтай холбоотой бусад ажлыг зохицуулах;

4.1.3. сангийн хөрөнгийг төвлөрүүлэх, зарцуулах болон бусад үйл ажиллагаатай холбогдсон иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын санал, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх.

4.2. Шаардлагатай бол зөвлөлийн шийдвэрийг Засгийн газарт танилцуулна.

Засгийн газрын 2012 оны 98 дугаар  
тогтоолын 20 дугаар хавсралт

АРХИДАН СОГТУУРАХТАЙ ТЭМЦЭХ САНГИЙН  
ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

<b>Зөвлөлийн дарга</b>	-Хууль зүйн сайд
<b>Гишүүд:</b>	-Эрүүл мэндийн дэд сайд;  -Хууль зүйн яамны Төрийн нарийн бичгийн дарга;  -Хууль зүйн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга;  -Цагдаагийн ерөнхий газрын дэд дарга;  -Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тэргүүн дэд дарга;  -Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтсийн дарга.
<b>Нарийн бичгийн дарга</b>	-Хууль зүйн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн.



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2013 оны 7 дугаар  
сарын 6-ны өдөр

Дугаар 271

Улаанбаатар  
хот

### **Журам шинэчлэн батлах, журамд өөрчлөлт оруулах тухай**

Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 8.7, Боловсролын тухай хуулийн 39.7-г тус тус үндэслэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны 78 дугаар зарлигийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Дэлхийн шилдэг их сургуульд оюутан суралцуулах журам”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2. Журмыг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг хянаж, жил бүрийн улсын төсөвт тусган санхүүжүүлэхийг Сангийн сайд Ч.Улаанд даалгасугай.

3. Энэхүү журам батлагдахаас өмнө улсын төсвийн хөрөнгөөр гадаад оронд бакалаврын зэргийн сургалтад суралцах гэрээ байгуулсан иргэдийн сургалтын төлбөрийг гэрээгээр тохирсон нөхцөлийн дагуу санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Гантөмөр, Сангийн сайд Ч.Улаан нарт даалгасугай.

4. “Журам батлах тухай” Засгийн газрын 2012 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн 19 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээл олгох журам”-ын зарим хэсгийг дор дурдсанаар өөрчилсүгэй:

1)1.2 дахь хэсэг:

“1.2. Энэхүү журам нь Монгол Улсын дээд боловсролын сургалтын байгууллагад бакалавр, магистр, докторын, гадаад орны дээд боловсролын сургалтын байгууллагад магистр, докторын зэргийн боловсрол эзэмшихээр зохих журмын дагуу элсэн өдрийн ангид суралцаж байгаа Монгол Улсын иргэнд хамаарна.”

2) 3.2 дахь хэсгийн “бакалаврт 2 жил” гэснийг “докторын дараах сургалтад хамрагдагчид 1 жил” гэснийг тус тус хассугай.

5. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан “Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр дэлхийн шилдэг их сургуульд суралцуулах журам



батлах тухай” Засгийн газрын 2011 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн 217 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Н.АЛТАНХУЯГ**

**БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ  
УХААНЫ САЙД**

**Л.ГАНТӨМӨР**

**САНГИЙН САЙД**

**Ч.УЛААН**

Засгийн газрын 2013 оны 271 дүгээр  
тогтоолын хавсралт

**ДЭЛХИЙН ШИЛДЭГ ИХ СУРГУУЛЬД  
ОЮУТАН СУРАЛЦУУЛАХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг зүйл

1.1. Төрөөс сургалтын зээл олгон дэлхийн шилдэг их сургуулийн бакалаврын зэргийн өдрийн ангид оюутан суралцуулахад энэхүү журмыг мөрдөнө.

1.2. Энэ журмын дагуу олгож буй сургалтын зээл нь Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 8.10-д заасны дагуу хөнгөлөлттэй, эргэн төлөгдөх нөхцөлтэй байна.

1.3. Дэлхийн шилдэг их сургуулиудын зэрэглэл тогтоодог олон улсад зөвшөөрөгдсөн “Times Higher Education World University Rankings” (THE) болон “Academic Ranking of World Universities” (ARWU) жагсаалтад багтсан их сургуулийг дэлхийн шилдэг их сургуульд тооцно.

1.4. Энэхүү журмын 1.3-т заасан жагсаалтын эхний 20-д багтсан их сургуулийн суралцагч мэргэжлийн чиглэл харгалзахгүйгээр, 21-100-д багтсан их сургуульд Засгийн газраас баталсан мэргэжлийн чиглэлээр суралцагч сургалтын зээлд хамрагдах хүсэлт гаргах эрхтэй.

1.5. Тухайн жилд дэлхийн шилдэг их сургуульд суралцуулах оюутны тоог Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тухайн оны 2 дугаар сард багтаан батална.

1.6. Дэлхийн шилдэг их сургуульд суралцуулах мэргэжлийн чиглэлийг Засгийн газар өмнөх оны эхний хагас жилд багтаан тогтооно.



1.7. Дэлхийн шилдэг их сургуульд суралцуулах мэргэжлийн чиглэл, тухайн жилд суралцуулах оюутны тоог Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь өөрийн цахим хуудас болон олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нээлттэй зарлаж, ил тод байдлыг хангана.

1.8. Сургалтын төрийн сан нь сургалтын зээлээр суралцагчид болон тэдний суралцаж буй их сургуультай харилцан мэдээлэл солилцож, мэдээллийн сан бүрдүүлнэ. Суралцагчдын нэр, сургууль, мэргэжлийн чиглэлийн талаарх мэдээллийг Сургалтын төрийн сангийн цахим хуудсанд байршуулна.

1.9. Сургалтын зээлийн санхүүжилтийг зөвхөн үндсэн ангийн суралцагчид олгоно.

1.10. Сургалтын зээлд хамрагдах иргэдийг сонгон шалгаруулах журам, сонгон шалгаруулалтыг зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнийг Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

1.11. Сургалтын төрийн сангийн зээлээр болон Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрийн дагуу гадаадын их, дээд сургуульд суралцах эрх авсан буюу суралцаж байгаа иргэн энэхүү журамд заасан сургалтын зээлд хамрагдахгүй.

#### Хоёр. Сургалтын зээлийн санхүүжилт

2.1. Дэлхийн шилдэг их сургуульд сургалтын зээлээр суралцуулахад шаардагдах зардлыг жил бүр улсын төсөвт тусгана.

2.2. Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нь дэлхийн шилдэг их сургуульд сургалтын зээлээр суралцуулах тухай шийдвэрийг гаргана.

2.3. Сургалтын зээлд сургалтын төлбөр болон амьжиргааны зардал багтана.

2.4. Сургалтын зээлийг тухайн их сургуулиас ирүүлсэн нэхэмжлэлийг үндэслэн үл хөдлөх эд хөрөнгө барьцаалан олгоно.

2.5. Сургалтын зээл олгох нийт хугацаа нь тухайн мэргэжлийн бакалаврын сургалтын үндсэн хугацаанаас хэтрэхгүй байна.



2.6. Сургалтын төлбөрийг суралцагчийн суралцаж буй их сургуулийн дансанд, амьжиргааны зардлыг суралцагчийн дансанд тус тус шилжүүлнэ.

### Гурав. Сургалтын зээлийн гэрээ

3.1. Сургалтын төрийн сан нь суралцагчтай сургалтын зээлийн гэрээ байгуулна.

3.2. Сургалтын зээлийн гэрээний загварыг Боловсролын болон Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

3.3. Сургалтын зээлийн гэрээнд талуудын эрх, үүрэг, гэрээний хугацаа, эргэн төлөгдөх нөхцөл, суралцагчийн болон итгэмжлэгдсэн төлөөлөгчийн талаарх мэдээлэл, гэрээг сунгах нөхцөл, суралцагчийн голч дүнд тавих шаардлага, барьцаа, чөлөөлөгдөх нөхцөл, гэрээний заалт зөрчигдсөн тохиолдолд талуудын хүлээх хариуцлага, гэрээг цуцлах, санхүүжилтийг зогсоох, энэ тохиолдолд олгосон зээлийг эргэн төлүүлэх нөхцөл зэргийг тодорхой тусгана.

### Дөрөв. Бусад зүйл

4.1. Энэхүү журмын дагуу дэлхийн шилдэг их сургуульд суралцагчийн сургалтын зээлийн хөнгөлөлт, эргэн төлөлттэй холбогдох асуудлыг Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 8.8 -д заасан журмаар зохицуулна.

4.2. Сургалтын зээлд хамрагдахыг хүсэгч нь энэхүү журамд заасан шаардлагыг хангаагүй, бичиг баримтаа дутуу, эсхүл хуурамчаар бүрдүүлсэн нь тогтоогдвол сургалтын зээл олгохгүй.

4.3. Сургалтын зээлийн гэрээ, зээлийн санхүүжилттэй холбогдон гарсан маргааныг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмаар зохицуулна.

#### Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци.  
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот

И-мэйл: [turiin\\_medecelel@parliament.mn](mailto:turiin_medecelel@parliament.mn)

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 0.5

Индекс: 14003